

ОРОЛЦОГЧИДОД ӨГӨХ ЗААВАР

Оролцогч лаборатори өгөх зааварчилгаа

Оролцогч ур чадварын сорилтонд оролцох боломжийг олгохоос гадна шинжилгээг саадгүй явуулахад ач холбогдолтой.

Ур чадварын сорилтын дээжийг дагалдан хөтөлбөр, шинжилгээний заавар дагалдах бөгөөд тухайн явуулж байгаа шинжилгээний заавар, техникийн шаардлагуудыг тусгаж өгсөнтэй танилцаж болно.

Сорилтыг буцаах

Ур чадварын сорилтыг зохион байгуулагч сорилт явуулах дээжийн мэдээллийг оролцогч байгуулагад урьдчилан *nrl.gov.mn* цахимаар мэдээлж тухайн дээжийн шинжилгээ хийх боломжтой эсэхийг тодруулна. Хэрэв оролцогч ур чадварын сорилтонд оролцох саналаа урьдчилан өгч хөтөлбөрийн дагуу дээжийг бэлдүүлэн тээвэрлэгчээс дээжийг хүлээж авсны дараа өөрсдийн бааз дээр суурьласан шинжилгээг хийх боломжгүй бол урьдчилан мэдэгдэж шинжилгээ бэлтгэсэн буюу хүргэгдсэн замын зардал болох төлбөрийг нэхэмжлэхийн дагуу буцааж төлнө.

Үр дүнг тайлагнах

Оролцогч лабораториуд шинжилгээ дууссны дараа дагалдах шинжилгээний зааварт өгөгдсөн тогтоосон хугацаанд зохион байгуулагч талруу бичгээр хүргүүлнэ. Шинжилгээний үр дүнгийн хуудас нь дараахи мэдээллийг агуулсан байна.

- Дээжийн тодорхойлолт /нэр, үйлдвэрлэгч, хүчинтэй хугацаа/;
- Шинжилгээ эхэлсэн ба дууссан огноо;
- Ашигласан шинжилгээний аргын стандарт, техникийн шаардлагын стандартын шаардлага;
- Шинжилсэн үзүүлэлтүүд;
- Шинжилгээний үр дүн;
- Шинжилгээ гүйцэтгэсэн, хянасан хүний гарын үсэг;
- Зөвхөн уг дээжийн шинжилгээтэй холбогдох үр дүнгийн мэдээлэл

Шинжилгээний дүнгийн хуудсын асуумжийн дагуу гаргацтай бөглөж тайлагнасан байхаас гадна. Нэмэлт хавсралтаар багажны хэвлэмэл дүн, математик боловсруулалт хийсэн тооцоо, нянгийн өсгөврийн ургасан зургийг явуулж болно.

Цахим хөтөлбөрт холбогдсон тохиолдолд ур чадварын хөтөлбөрийн мэдээллийг авах боломжтой. Цахим бүртгэлд холбогдсноор зөвхөн дээжээ хүргүүлэн хөтөлбөрт оролцох хүсэлт, шинжилгээний заавар, бусад мэдээлэл, илгүүлэх тайлан , гэрчилгээг авч болно.

Сорилт гүйцэтгэх орчин нөхцөл, шалгуур

Оролцогч шинжилгээг гүйцэтгэх нөхцөл бүрдүүлсэн лабораторийн орчинд хийж гүйцэтгэх бөгөөд тухайн орчны нөхцөл хэмжлийн үр дүнд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээс гадна

шинжилгээний өрөө тасалгаанууд нь температурын хэлбэлзэл, тоос, чийг, уур, шуугиан, чичиргээ цахилгаан соронзон хэлбэлзэл зэрэг хүчин зүйлийг бүрэн хамгаалагдсан хянах тогтолцоотой, нөхцлийн судалгааг хийлгэсэн байвал зохино.

Оролцогч лаборатори нь ур чадварын сорилтын хөтөлбөрт хамрагдахдаа доор дурдсан шаргуурыг хангаж байх шаардлагатай.

- Стандарт арга, аргачлалтай байх;
- Сорилт гүйцэтгэх тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
- Боловсон хүчин нь тухайн шинжилгээг гүйцэтгэх чадавхитай байх;

Сорилтын дээж хүлээн авах, гэмтсэн дээжийг хэрхэн шийдвэрлэх

Сорилтын ур чадварыг үнэлэх бүдүүвчийн дээж оролцогч лабораторид очоогүй буюу замдаа гэмтсэн, задарсан тохиолдолд ур чадварын сорилтын лабораторитой холбоо барьж яаралтай арга хэмжээ авна. Ур чадварын сорилтын лаборатори нь дээж гэмтсэн болон задарсан мэдээллийг бүртгэн авч дахин дээж хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн авч ажиллана.

Оролцогч лабораториуд дараах шалгуурын хүлээн авна. Үүнд:

Тээвэрлэлийн үед хадгалалтын горим зөрчигдсэн эсэхийг нягтална. Хэрэв горим зөрчигдсэн байвал тээвэрлэлт хийж хүргэсэн газраас тодруулга хийнэ.

Дээжийн лац бүрэн эсэх, дээжийн нөхцөл, хүлээн авч болох эсэхийг шалгаж баримтжуулна.

Дараах нөхцөлд ур чадварын хөтөлбөр зохион байгуулагчидад мэдэгдэн, дээжинд шинжилгээ хийхээс татгалзаж болно.

-сорилтын дээжийн савлагаа гэмтсэн, битүүмж алдагдсан, асгарсан, гоожсон

-дээж дутуу хорогдсон;

-очих газрын нэр болон хаяг дутуу, хугацаандаа очоогүй

-лабораторийн эрхлэгийн зөвшөөрлөөр дээрх шаардлага хангаагүй дээжинд шинжилгээ хийхгүй баримтжуулан нян судлалын дээжийг халдваргүйжүүлэн / 10-20 % ариутгалын бодис /дулаан боловсруулалт / автоклавын 130⁰С- 30 мин / хийж устгана.

Дээжийг хүлээн авахдаа дараах мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтөлнө.

-сорилтын дээж хүлээн авсан хугацаа. он. сар. өдөр.

-сорилтын дээжийн бүрэн бүтэн байдал, битүүмжлэл, тоо хэмжээ, бусад дагалдах бичиг баримт, -тээвэрлэлтийн мэдээлэл, хадгалах нөхцөл гэх мэт